



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/64

Мөрөн

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Мөсний баяр”-ын арга хэмжээг зохион байгуулагч “Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо”-ноос ирүүлсэн саналыг үндэслэн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. “Мөсний баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 5 000 000 /таван сая/ төгрөгийг “Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо”-нд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжаар зөвшөөрсөн хөрөнгийн зарцуулалтын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбооны тэргүүн /Д.Наранчимэг/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР